



МОНГОЛЫН  
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН  
САН

# ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХИЙГ НЭМЭГДҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ



# МОНЭС

ЖИЛИЙН ТАЙЛАН 2005



## ТАНИЛЦУУЛГА

Монголын Эмэгтэйчүүдийн Сан /МОНЭС/ нь 2000 оны Долдугаар сард байгуулагдсан бөгөөд одоогоор 6 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Манай сан ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг Төрийн Бус Байгууллага бөгөөд Эмэгтэйчүүдийн Төрийн Бус Байгууллага /ЭТББ/ болон эмэгтэйчүүдийн үүсгэл санаачлагын бүлгүүдэд санхүүжилт олгодог ҮНДЭСНИЙ АНХДАГЧ САН юм.

### Бидний сүлжээ

Манай сан Олон Улсын Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээ, АНУ-ын Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээ, "Хил Хязгааргүй Тэтгэлэг Олгогчид" Сүлжээ, Хөгжил дэхь эмэгтэйчүүдийн эрхийн төлөө холбооны гишүүн байгууллага юм.

### Хэтийн зорилго

Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын бүхий л салбарт эмэгтэйчүүдийн тэгш оролцоо бүхий хүмүүнлэг, энэрэнгүй, ардчилсан, иргэний нийгмийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулна.

### Эрхэм зорилго

Монголын эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлийн төлөө нөөц баялгийг хуримтлуулж санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

### Үнэт зүйлс

Бид:

- Эмэгтэйчүүд хүч чадалтай гэдэгт итгэдэг.
- Эмэгтэйчүүд нэгдсэнээр амжилтанд хүрнэ гэдэгт итгэдэг.
- Эмэгтэйчүүдийн тэгш оролцоотой нийгэм тогтвортой хөгжинө гэдэгт итгэдэг.
- Эмэгтэйчүүд нийгмийг өөрчилж чадна гэдэгт итгэдэг.
- Ил тод, шударга ёсонд итгэдэг.
- Хүн бүхэн бусдын сайн сайхны төлөө "ХАНДИВЛАГЧ" гэдэгт итгэдэг.

### Зорилт

1. Монголын Эмэгтэйчүүдийн Төрийн Бус Байгууллага /ЭТББ/, бүлгүүдэд тэтгэлэг олгоно.
2. Дотоод гадаадын эх үүсвэрүүдээс мөнгөн сан бүрдүүлнэ.
3. Бусдыг хайрлах, тэтгэн туслах ФИЛАНТРОПИ үзэл хандлагыг түгээн дэлгэрүүлж, олон нийтийг төлөвшүүлнэ.
4. Байгууллагын олон талт хамтын ажиллагааг хөгжүүлж чадавхийг бэхжүүлнэ.

### Үйл ажиллагааны хөтөлбөр

1. Тэтгэлэг олгох хөтөлбөр
2. Сан бүрдүүлэх хөтөлбөр



## АГУУЛГА

### МЭНДЧИЛГЭЭ

3

### ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ХӨТӨЛБӨР

- Танилцуулга 6
- 2005 онд олгосон тэтгэлэг 7
- Тэтгэлэгийн үр дүнг сайжруулах хүрээнд хийгдсэн үйл ажиллагаанаас... 11

### САН БҮРДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

- Танилцуулга 16
- Хандивлагчийн мэндчилгээ 16
- Сан бүрдүүлэх арга хэмжээнүүд 17
- Сан бүрдүүлэх кампанит ажлууд 18

### ГЭГЭЭРЛИЙН ХӨТӨЛБӨР

- Танилцуулга 20
- Хандивын өдөр /2005.11.15-17/ 21

### МОНЭС-ийн ХАМТ ОЛОН

- Тэтгэлэг авагч байгууллагын мэндчилгээ 24
- Бүтэц, зохион байгуулалт 25
- Онцлох үйл явдалууд 27

### ХАНДИВЛАГЧДЫН НЭРС

29

### САНХҮҮГИЙН ТАЙЛАН

34

Энэ дэлхий дээр бүхий л эрх зүүнд хүн  
нэгдэж агуу. Тэхдээ түүнийг бий болгосон  
эг эс бүхэн эмэгтэй хүнийх.

Цолін Цитмен



# ТЭРГҮҮНИЙ МЭНДЧИЛГЭЭ

## Эрхэм хатагтай, ноёд оо

Та бүхэнтэйгээ шинэ оны босгон дээр дахин уулзан золгож байгаадаа баяртай байна.

Монголын Эмэгтэйчүүдийн Сан үүссэн цагаасаа эхлэн эмэгтэйчүүдийг хөгжүүлэх, тэдний байр суурийг дээшлүүлэх замаар нийгмийн амьдралыг өөрчилж шударга ёсыг тогтооход хувь нэмрээ оруулахын тулд өгөөмөр сэтгэлтэй сайн санаат хүмүүс, байгууллагуудын хандив туслалцаатайгаар хөрөнгө мөнгө хуримтлуулж эмэгтэйчүүдийн бүлгүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлсээр ирлээ.

Бидний нэг чухал зорилго бол бусдын сайн сайхны төлөө, нийгмийн хөгжлийн төлөө нинжин сэтгэлийн гараа сунгаж хандив өргөх дэлхий нийтийн үзэл болох филантропи сэтгэлгээг нийгэмд төлөвшүүлэх явдал юм. Нийгмийн хөгжлийн тусын тулд хичээн зүтгэж байгаа олон нийтийн байгууллагад хандив өргөдөг дадал заншил манай нийгэмд тогтоогүй байна.

Олон нийтийн байгууллагууд нь сайн дураараа нийгэмдээ хувь нэмрээ оруулж, төрийн хүрч үйлчлээгүй газарт хүрч иргэддээ тусалж, иргэдийн дуу хоолойг зохих шатны байгууллагад хүргэж байдаг гүүр юм. Тийм болохоор манай сан ч ялгаагүй эмэгтэйчүүдэд хүрч тэднээр дамжуулан нийгмийг өөрчлөхөд хувь нэмрээ оруулахаар хичээн ажиллаж байна.

Эмэгтэйчүүдийн санаачлага, шилдэг арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх, бие биенээсээ суралцах, баг болж хамтран ажиллах боломжийг нээж өгөх, хөгжүүлэх зэргээр эмэгтэйчүүдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх замаар нийгмийг өөрчлөх, шинэчилэх алхамууд эрчимтэй явуулахад санхүүгийн дэмжлэг туйлаас чухал.

Би эмэгтэй хүнийг хатууг зөөлөлж, хүн хүнээ хайрлах, амар амгалан ертөнцийг бий болгохын төлөө өөрсдийгөө зориулж чаддаг хүмүүс гэж боддог. Тэд сайн сайханд тэмүүлдэг шигээ хүмүүнлэг энэрэнгүй нийгмийн үндэс суурийг цэцэглүүлж чадна гэдэгт би огт эргэлздэггүй.

Монголын Эмэгтэйчүүдийн Санд тусалсан, хамтарч ажилласан бүх хүмүүст өөрийнхөө болон хамт олныхоо нэрийн өмнөөс гүн талархал дэвшүүлье.

Та бүхний бусдын төлөө гэсэн ариун буянтай үйлс тань жилээс жилд өсөн нэмэгдэж байхын өлзийтэй сайхан ерөөлийг өргөн дэвшүүлье.



Тэргүүн Ш. ЦЭВЭЛМАА  
/Монгол Улсын анхны  
Тэргүүн Хатагтай/

*“Би МОНЭС-ийн ирээдүйд итгэдэг. Яагаад гэвэл өөрчлөгдөж хөгжиж байгаа эмэгтэйчүүдийг хараад зогсох эрхгүй гэдгээ ойлгодог.”*

*Ш. Цэвэлмаа*

Тэргүүн Ш. ЦЭВЭЛМАА



## ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Захирал Н.ЧИНЧУЛУУН  
Лүүсгэн байгуулагч

*“Эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлуудыг өөрчлөхийн тулд өөрсдийн чадах хэмжээнээс эхлэх, дараа нь хөгжүүлэх”*

### Эрхэм найзууд аа.

Монголын Эмэгтэйчүүдийн сан үүсэн байгуулагдсанаас хойш 5 жил өнгөрлөө. 2005 онд бидний хувьд хэд хэдэн онцлог үйл явдлууд болж өнгөрсөн.

- МОНЭС өнгөрсөн онд эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхийг дэмжихэд илүү анхаарч ажиллалаа. Тэтгэлэгийн 62.86% нь энэ чиглэлд зориулагдсан ба шинэ технологи, аргачлалыг эмэгтэйчүүдэд эзэмшүүлж дадлагажуулах, түүгээрээ дамжуулан амьдралын баталгаагаа сайжруулах нь юу юунаас чухал байна гэж бид үзсэн нь зохих үр дүнгээ өгсөн.
- Монгол Улсад анх удаа Азийн бүсийн эмэгтэйчүүдийн сангуудын уулзалт зохион байгуулагдсан нь бүсийн хөгжилд эмэгтэйчүүдийн сангуудын гүйцэтгэх үүргийг улам баяжуулж өглөө. Мөн Олон улсын Эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлээс суралцах, туршлага солилцох сайхан боломжууд бас олдсон юм.
- Мөн өнгөрсөн таван жилд бид юу хийв? Дараагийн жилүүдэд юу хийх вэ? гэж өөрсдийн үйл ажиллагаандаа үнэлгээ дүгнэлт хийсэн. Олон улсын сангуудын зөвлөхүүд ирж бидэнд үнэтэй сайхан зөвлөгөө өгсөн. Байгууллагаа хөгжүүлэх “Ухаалаг хөгжил” сургалт нь МОНЭС-ийн хөгжлийн стратегийг улам боловсонгүй болгоход тусалсан. Харин “нийгмийн өөрчлөлт гэж юу вэ?” гэсэн тэтгэлэг авагчдын үр дүнг үнэлэх аргачлал нь бид эмэгтэйчүүдийн бүлгүүдтэй хэрхэн ажиллах болоод эмэгтэйчүүдийн хөдөлгөөний хөгжлийг сайжруулахад анхаарах хүчин зүйлүүдийг таньсан сайхан сургалт байлаа.
- МОНЭС өөрийн ажлын байртай боллоо. Дэлхийн Эмэгтэйчүүдийн сан, Мама Каш сангийн өгөөмөр дэмжлэг болон дотоод нөөцөөрөө 4 өрөө орон сууцны байр худалдан

авлаа. Энэ нь МОНЭС-ийн цаашдын хөгжилд үнэлэгдэхүйц үр өгөөжөө өгнө гэдэгт итгэлтэй байна. Биднийг байнга анхааран тусалж байдаг найзууд даа баярлалаа.

2006 он бол эмэгтэйчүүдийн байр суурийг дээшлүүлэхэд илүү анхаарсан жил байна. Монголын эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг шинэ шатанд гаргахын тулд Улаанбаатар хотын болон хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдийн бүлгүүдийн идэвхи санаачлагыг улам өрнүүлж ажиллах болно. Тийм ч учраас Азийн эмэгтэйчүүдийн сангуудын санаачлагаар өрнөсөн “Олон Улсын Хүний Эрхийн Өдрөөс Эмэгтэйчүүдийн Эрхийн Өдөр хүртэл 88 хоногийн турш 1000 хүнээс хандив цуглуулах” аянг зохион байгуулж байна. Энэ хуримтлуулж буй мөнгөөрөө ажлын байран дахь бэлгийн дарамтлалыг бууруулах үйл ажиллагааг өмнөх жилүүдээс илүү анхаарч эрчимтэй ажиллах юм.

Мөн 2006 онд бид өөрсдийн багаа улам сайжруулж, бэхжүүлэх шинэ шинэ арга замуудыг турших болно. Өөрөөр хэлбэл Удирдах Зөвлөл болон сайн дурынханы идэвхи санаачлагыг өрнүүлэх олон чухал арга хэмжээнүүд зохион байгуулна. Монголын эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг олон улсын санхүүжүүлэгч нарт таниулах олон талт ажлуудыг хийхээр төлөвлөсөн байна.


Бидний үйл хэргийг ямагт дэмжиж, хамтарч байдаг донорууд, хандивлагчид болон тэтгэлэг авагч нартаа баярлалаа. Нэг баг болж сэтгэл зүрхээ эмэгтэйчүүдийн үйл хэрэгт зориулдаг Удирдах Зөвлөлийнхэн, сайн дурынхан, зөвлөхүүд, гүйцэтгэх албаны гишүүддээ сайн сайхныг хүсэн ерөөе.

Захирал Н.ЧИНЧУЛУУН



# ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ХӨТӨЛБӨР

Бид монголын охид, эмэгтэйчүүдийн  
хөгжил дэвшлийн төлөө тэтгэлэг  
олгоно.





## ТАНИЛЦУУЛГА

Тэтгэлэг олгох хөтөлбөр нь МОНЭС-ийн үйл ажиллагааны гол цөм бөгөөд эмэгтэйчүүдийн хүний эрхийг хамгаалах, хөгжүүлэхийн төлөө эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага, бүлгүүдээс ирүүлсэн санал санаачлагыг хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилготой.

Тэтгэлэг олгох хөтөлбөр нь:



- Эмэгтэйчүүдийн эрх,
- Эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдлыг сайжруулах,
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг дэмжих чиглэлээр тэтгэлэг олгодог.

2005 оны хувьд охид, эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдлыг сайжруулах буюу орлого нэмэгдүүлэх, жижиг бизнес эрхлэх чиглэлээр ажилладаг эмэгтэйчүүдийн бүлгүүдийг чухалчлан үзэж Улаанбаатар хот, 9 аймгийн эмэгтэйчүүдийн бүлэгүүдийн амьдрал бодит өөрчлөлтийг бий болгож, нийт тэтгэлэгийн 62.86 хувийг энэ чиглэлд зарцууллаа.

2006 онд эмэгтэйчүүдийн эрх, эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг идэвхижүүлэхэд анхаарч, нөлөөллийн ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

## 2005 ОНД ОЛГОСОН ТЭТГЭЛЭГ

2005 онд МОНЭС нийт 130 төслийн санал хүлээн авч 35 төсөлд 27 541 200 төгрөгийн ТЭТГЭЛЭГ ОЛГОЛОО.





## ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Хөдөлгөөнтэй ажил, Үндэстэн  
Гэгээдлийн Төв, "Хөдөлгөөн  
Команс" төсөл 400, 000 ₮

Дамжлын зорилготой аж, Бэйгийн  
Хүн Аж, Эмэгтэйчүүдийг Шинэ Ном,  
Сонин, Сэтгэл, Төрийн Бодлол,  
Ууль Талтэрхж, Иргэний Нийгмийн  
Байгууллагудын Үеэр, Үндэстэнтэй  
Нэг Төлбөргүй Илчилж Үндэстэн  
Ож Асар Эрдмийг Хөгжөөд Тусгай Ком,  
Номын Баржлуулалт Илгээнэ.

"Эмнести Интернэшнл" ОУБ,  
"Нобелийн шагналд нэг дөвшөн  
эмэгтэйчүүдийн тухай баримтат  
олно хийх" төсөл 500, 000 ₮

Олон улсын Эмнести Интернэшнл  
байгууллагын Монгол дахь салбар  
"Ажар тайван амьдралын учир"  
нэртэй, Монголын төрийн болон  
төрийн бус байгууллагуудаас сонгон  
шалгарсан 10 эмэгтэйн амьдрал,  
эмгийн төгөөх үйлсийг харуулсан  
баримтат кино хийсэн. Энэхүү киног  
нэг кино найруулагч Г.Хөгжидсүрэн

найруулсан ба энти, монгол орт дээр  
хөдөлгөөн дотой нийгмийн нэгдэлт  
болгонод.

Хөгжлийн Бэрхшээлтэй Хүндэтгэн  
Эцэг Эхийн Холбоо, "Бид  
Эрдэмтэй Хүснэ" төсөл 500, 000 ₮

Эрдэнэ аявастай, сонирхолтой  
10 хөгжлийн бэрхшээлтэй охиныг  
хөгжлийн зидвандын үдэн эрдэмтэн  
сидгалтанд хөгжүүлж, охинод өөстөө  
алтга алтэгийг бий болгож, аявастыг  
нь хөгжүүлэн эсрэгилтэй.



"Бид зурхайг хүснэ төсөл",  
ХӨХЭХолбоо, ҮБ хот

Монголын Эцэг Бүлгийн Ажил  
Хүснэ Эмэгтэйчүүдийн Холбоо,  
"Хөдөлгөөн Сидгалт" төсөл  
1, 000, 000 ₮

Төв ажилчин эрх 2 оюу, Хөгжлийн  
Ажилчин Бүлэг 3 оюу, Батангид  
Эрдэмтэн 4 хөдөлгөөн нийт 100 гаруй  
хөгжөөд эмэгтэйчүүдэд хөдөлгөөн  
технологийн сидгалт явуулж  
интернэлийн илчилгээнд талон  
сидгалтуудад эмэгтэйчүүдийн  
хөдөлгөөн оюу асар хөгжөөд оюу

Хүнчилгээний Эцэг Үндэстний  
Төв, "Чуулган Зохихон Байгуулах"  
төсөл 1, 445, 000 ₮

Гэр бүлийн хүнчилгээний эцэг  
өрсөн үндэстний хөдөлгөөний үр  
дүнд нийгэмд гарсан өөрчлөлтийг  
үнэтэй, олон нийгэмд таниулах,  
хөгжлийн цаашдын чиг хандлагыг  
тодорхойлох зорилготой төрийн  
болон төрийн бус байгууллага,  
олон нийгмийн оролцоотой үндэстний  
чуулга уулзалт зохион байгуулагдана.  
Өнгөрсөн 10 жилийн хугацаанд  
ХӨҮТ үрсэн ололт амжилтаа дүгнэх,  
үндэстний хөдөлгөөний үр дүнд  
нийгэмд гарсан өөрчлөлтийг  
үнэтэй.

## ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

Сайн Санаат Эмэгтэйчүүдийн  
Холбоо, "Эрдмийн өгөөх" төсөл  
1,000,000 ₮

Сэлэнгэ аймгийн Мандал суманд:  
Вүүн хараа хот/хос үсчний  
сургалтанд 5, худалдагч, нярав кассын  
сургалтанд 8, тогоочийн сургалтанд  
12, гоо заслын сургалтанд 5 хүнийг  
ажлын 22 өдрийн бүрэн хэмжээний  
сургалтанд хамруулж, дадлага хийлгэн  
сертификат олгоно. Сургалтын  
дараа тогооч мэргэжилтэй 8, үсчин  
3, гоо засалч 2, худалдагч 6 хүн  
сумандаа ажлын байртай болов.

Хүүхдийн төлөө "Амьдрах ухаан"  
төв, "Торго уйлуулахаар даалдима  
инээлэг" төсөл 800,000 ₮

20-25 насны 15 эмэгтэйг байнгын  
орлоготой болоход нь туслахын  
тулд нэхмэл, үндэстний хатгамал,  
эсгий урлал, оёдлын сургалтанд  
хамруулж дадлагажуулах, бүтээгдэхүүн  
үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулав.

Үүний үр дүнд дорх эмэгтэйчүүдийн  
ерхийн орлого 30-40 мянган  
тегерегээр нэмэгдэв. 2 эмэгтэйд  
оёдлын машин авч өгсөн ба ажлын  
хувцас, цагаан хэрэгсэл гэх мэт  
оёдлын захиалга олж өгч байна.

Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн  
Холбооны СХД-ийн салбар зөвлөл,  
"Үсчин" төсөл 500,000 ₮

СХД-ийн эмэгтэйчүүдийг ажлын  
байраар хангах зорилготой "Үсчин"  
нэртэй энэхүү төслийн хүрээнд СХД-т  
амьдардаг үсчний мэргэжил эзэмших,



Үсчний сургалтанд хамрагдаж буй  
эмэгтэйчүүд сургалтын үеэр

ажил хөдөлмөр эрхлэх сонирхолтой  
нэн ядуу 3, өрх толгойлсон 4,  
амьжиргааны баталгаат түвшингээс  
доогуур 4, нийт 11 лүүнээс 1 эрэгтэй/  
хүн шинээр үсчний мэргэжил эзэмших  
1 сарын сургалтанд хамрагдах 100%  
ажлын байртай боллоо.

"Ивээл" нийгэмлэг, "Ажлын байр-  
Эмэгтэйчүүд" төсөл 500,000 ₮

Амьдралдаа алдаж эндэж явсан 10  
эмэгтэйг мэргэжлийн чиг баримжаа  
олгох сургалтанд хамруулж, ажлын  
байртай болоход нь тусална.

Лэтгэлэгийн хугацаа дуусаагүй

Хүний Эрх ба Хөгжил Төв,  
БЗД-ийн 10-р хорооны  
эмэгтэйчүүдийн бүлэг, "Хөггүй  
орчин" төсөл 1, 000, 000 ₮

Шахмал түлш хийх, хаягдал хог  
ашиглах, хүнсний ногоо тариалах,  
цементэн блок үйлдвэрлэх зэрэг үйл  
ажиллагаа явуулж 9 хүний амьдралд  
бодит хувь нэмэр оруулсан.



**ЭТББ-ын сүлжээний Багануур дүүрэг дэхь салбар зөвлөл, "Өрхийн аж ахуй" төсөл 991.000 ₮**

Нийт 3 га газар 50 ядуу өрхийн эмэгтэйчүүдийг 5 бүлэг болгон ажиллуулж хүнсний ногоо тариалсан. Нийтдээ 12 тн төмс, 2 тн лууван хураан авсан ба төсөлд хамрагдсан өрхүүдийн амьжиргаанд бодит өөрчлөлт гарсан. Амьдрах ухааны сургалт 2 удаа, зохион байгуулсан.

**Тэргэнцэртэй иргэдийн "Төмөр" сангийн дэргэдэх эмэгтэйчүүдийн бүлэг, "Дээж" төсөл 1.000.000 ₮**

Тэргэнцэртэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Нуруу нугасны гэмтэлтэй 2 эмэгтэй, нийт 6 хүн сүүний цехэд ажиллаж ажлын байртай, амьжиргааны эх үүсвэртэй болоод байна.

**Эмэгтэйчүүд Хүүхэд Хөгжлийн "ЭХ САН" төв, "Үзэсгэлэн зохион байгуулах" төсөл 300.000 ₮**

Гар урлал эрхлэгч эмэгтэйчүүдийн бүтээлийг нийтэд сурталчлах, зах зээлээ олоход нь туслах зорилгоор гар урлалын үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдав.

**Дархан-Уул аймаг, Орхон сум, Хөдөөгийн Эмэгтэйчүүдийн Хөгжлийг Дэмжих Сангийн салбар зөвлөл, "Шинэ талх" төсөл 900.000 ₮**

Орхон сумын хэрэглэгчдэд шинэ технологийн амт, чанартай талх нийлүүлж, 6 эмэгтэй ажлын байртай болж ажилгүйдлийг бууруулах зорилготой.

**/тэтгэлэгийн хугацаа дуусаагүй/**

**Сэлэнгэ аймаг, Ерөө сум, "Ардын элч" хөдөлгөөн, "Өрхийн аж ахуй" төсөл 800.000 ₮**

Өрхийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх зорилготой төслийн хүрээнд Ерөө сумын 6 эмэгтэй хөдөлмөрөө хоршиж, хүнсний ногоо тариалах, худаг гаргах зэргээр амьжиргаагаа дээшлүүлнэ.

**/тэтгэлэгийн хугацаа дуусаагүй/**

**Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбооны Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөл, "Эсгий урлал" төсөл 600.000 ₮**

20 эмэгтэйг "Эсгий урлал" сургалтанд хамруулж, цаашид сурсан мэдсэнээ ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж бүрдүүлнэ.

**/тэтгэлэгийн хугацаа дуусаагүй/**

**Говьсүмбэр аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөл, "Буян" төсөл 700.000 ₮**

Бага орлоготой малчин 10 эмэгтэйг үйлдвэрлэгч болгох замаар талх, нарийн боовны цех ажиллуулж бодит орлогыг нь нэмэгдүүлнэ.

**/тэтгэлэгийн хугацаа дуусаагүй/**

**Увс аймаг, ХЭХДС-ийн салбар зөвлөл, "Үйлчин 10" төсөл 700.000 ₮**

Улаангом хотын 1-р багийн 10 эмэгтэй сумын захиргаанаас гаргаж өгсөн ажлын байрыг өөрсдийн хүчээр тохижуулсан. Төслийн мөнгөөр түүхий эд материал худалдан авч оёдол хийж эхэлсэн. Төслийн хугацаанд эмэгтэйчүүдийн бодит орлого нэмэгдсэн.

**Говь-Алтай аймаг, Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Холбооны салбар зөвлөл, "Халамж - ажлын байр" төсөл 600.000 ₮**

Аймгийн төвийн өрх толгойлсон 5 эмэгтэй, тэдгээрийн охид мөн өрх толгойлсон 5, нийт 10 эмэгтэйд оёдол эсгүүрийн мэргэжил олгох, хөдөлмөрийн багаж болох оёдлын машинаар хангах зорилготой. Төслийн хүрээнд гэр ажлын байр бий болгож өрх тус бүрд оёдлын машин авч өгсөн нь гэрээрээ үйлдвэрлэл явуулах боломж олголоо.

**Өвөрхангай аймаг, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн салбар зөвлөл, "Гуанз" төсөл 700.000 ₮**



**"Гуанз" төсөл, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн салбар зөвлөл, Өвөрхангай аймаг**

Уг төсөл нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, тус төвөөр үйлчлүүлдэг эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах зорилготой юм. Арвайхээр сумын ЗДТГ-ын хоолны заалыг түрээсэлж, 4 эмэгтэй хамтран хоолны газар ажиллуулж байна. Төслийн хүрээнд хоолны газарт шаардлагатай хөлдөөгч, шарах шүүгээ, бусад дагалдах хэрэгслийг авсан. Эмэгтэйчүүдийг сургалтанд хамруулж зохих мэдлэг, чадварыг эзэмшүүлсэн.

**Төв аймаг, Сүмбэр сум, Эмэгтэйчүүдийн зөвлөл, "Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийг дэмжих" төсөл 750.000 ₮**

Нийт 3 га газар хүнсний ногооны тариалалт эрхлэх замаар Сүмбэр сумын 10 эмэгтэйн орлого нэмэгдүүлэх зорилготой төслийн хүрээнд төмс, байцаа, манжингаас гадна хүлэмжинд өргөст хэмх, улаан лооль зэрэг нарийн ногоо тариалав. Нийт төслийн эцэст 1 445 250 төгрөгний борлуулалт хийж дараа жилийн үрийн төмсөнд 808 000 төгрөг хадгалж цэвэр ашиг 1 661 110 төгрөг олж эдгээр эмэгтэйчүүдийн амьдралд хувь нэмэр оруулав.

**Ховд аймаг, Жаргалант сум, Эмэгтэйчүүдийн "Жинст" бүлэг, "Сүү шим" сургалт явуулах, эргэлтийн хөрөнгө оруулах төсөл 3.256.200 ₮**

Ховд аймгийн төвд 15 эмэгтэйд 6 өдрийн "Сүү шим" сургалт явуулж, нийт 60 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн, тэр дундаа шар сүүгээр сүүн бүтээгдэхүүн хийж сургалаа.



**"Жинст" эмэгтэйчүүдийн бүлэг, "Сүү шим" сургалт, Ховд аймаг**



Сургалтаар сурсан мэдсэнээ амьдралд хэрэгжүүлж, амьдралаа дээшлүүлэх зорилгоор 6 эмэгтэй "Жинст" хэмээх бүлэг байгуулж, эхний ээлжинд 4 төрлийн бүтээгдэхүүн хийж эхлээд байна. Энэ бүлэгт түүхий эд, хөргөгч, плитка, сав суулга зэрэг тоног төхөөрөмж, сав баглаа боодол худалдан авахад зориулж 1.0 сая төгрөгний тэтгэлэг олголоо.

/тэтгэлэгийн хугацаа дуусаагүй/

Хөвсгөл аймаг, Мөрөн хот, Эмэгтэйчүүдийн бүлэг, "Увидас" төсөл 200.000 ₮

Бүлгийн ахлагч Я. Отгон нь аймагтаа уран оёдоогоороо нэртэй эмэгтэй. Тэрээр мэдлэг, чадвараа 5 эмэгтэйд зааж сурган бүлэг ажиллуулж, тэдний орлогыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Оёдлын түүхий эд материал худалдан авч малчдын захиалгаар монгол дээл, хантааз, монгол гутал үйлдвэрлэж эхлээд байна.

/тэтгэлэгийн хугацаа дуусаагүй/

Хөвсгөл аймаг, Хатгал сум, Эмэгтэйчүүдийн бүлэг, "Амтлаг" төсөл 500.000 ₮

Хатгал тосгоны дэргэдэх жуулчны баазуудын ихэнх нь Мөрөн сумаас нарийн боов, талхны хэрэгцээгээ хангадаг нь амрагчдыг шинэ талх нарийн боовоор хангахад бэрхшээлийг учруулдаг байна. Хатгалын иргэдийг шинэ талх нарийн боовоор хангах зорилгоор үйл ажиллагаа явуулж эхлээд байна.

/тэтгэлэгийн хугацаа дуусаагүй/

Хөвсгөл аймаг, Хатгал сум, Эмэгтэйчүүдийн бүлэг, "Уран нэхээс" төсөл 500.000 ₮

Хатгал тосгоны онцлогт тохирсан брэнд бүтээгдэхүүн хийж жуулчдад борлуулах замаар нийт 21 хүний орлогыг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн загвар бүлэг болохоор ажиллаж байна. Төсөлд хамрагдсан эмэгтэйчүүд бүгд гэрээр гар урлал эрхэлдэг бөгөөд бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, тоог нэмэгдүүлэх байдлаар орлого нэмэгдүүлэх юм.

/тэтгэлэгийн хугацаа дуусаагүй/

"Улаанбаатар-Зонта" ТББ "Танд туслая" төсөл 1.000.000 ₮

Чингэлтэй дүүргийн 10-р хорооны 30 өрхийн амьжиргааг дээшлүүлэх, тус хорооны нэг гудамжийг үлгэр жишээ гудамж болгохын тулд 30 хүнийг амьдрах ухааны сургалтанд хамруулж, хашаанд нь мод тариалах, зүлэгжүүлэх үйл ажиллагаа явуулна.

/тэтгэлэгийн хугацаа дуусаагүй/

Хөвсгөл аймаг, Мөрөн хот, Эмэгтэйчүүдийн бүлэг, "Ундарга" төсөл 300.000 ₮

Төслийн хүрээнд өрх толгойлсон 5 эмэгтэйг бүлгийн зохион байгуулалтанд оруулж, нарийн боовны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх замаар эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлнэ.

/тэтгэлэгийн хугацаа дуусаагүй/



Н. Лхагвасүрэн ахлагчтай эмэгтэйчүүдийн бүлэг, "Ундрага" төсөл, Хөвсгөл аймаг

*Хүнд хичнээн сайн таваар байна, түүнд тогтоон амьдрах байна.*

*Рольф Эмерсон*

*Сайн үйлс бүтээхэд бүсдин адайн бүү яв  
Буйны үйлсэд оорийн гадах  
хэмжээгээс багш бүү хий  
Хүн Цүйген*

*Хэний зурх олхи төлөө цохилж байна тэр үнэхээр агцу.*

*Ромек Ромна*



# ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР:

Ардчиллын Боловсролын Төв,  
"Тэтгэлэг олгогоч байгууллагуудын  
лавлагаа" төсөл 1.000.000 ₮

Дотоодод үйл ажиллагаа явуулж  
тэтгэлэг олгодог 35 төрийн бус сан,  
бизнесийн, олон улсын ба гадаадын  
байгууллагуудын талаархи мэдээллийг  
багтаасан "Тэтгэлэг олгогч  
байгууллагуудын лавлагаа" ном  
бэлтгэн гаргалаа. Төслийн санхүүжилт  
мэдээлэл цуглуулах, ангилах, шивэх,  
орчуулахад зарцуулагдсан бөгөөд  
Мерси Кор-ын Тан хөтөлбөрөөс  
500 ширхэгийг хэвлүүлэх зардалыг  
гаргасан болно.

Хүчирхийллийн Эсрэг Үндэсний  
Төв, "Зөвлөгөө өгөх үйлчилгээг  
сайжруулах" төсөл 500.000 ₮

Хүчирхийлэлд өртсөн хүмүүст  
өгөх сэтгэл зүйн зөвлөгөөг  
тогмолжуулахын тулд сэтгэл зүйчийг  
5 сарын хугацаанд цалинжуулав.  
Энэ хугацаанд нийт 270 хүнд сэтгэл  
зүйн зөвлөгөө өгч мэдээллийн  
санд орууллаа. Үүнээс 260 эмэгтэй,  
17 эрэгтэй, 3 нь хүүхэд байлаа.  
Үйлчлүүлэгчийг дэмжих, идэвхижүүлэх  
үүднээс төвд болон, хамгаалах  
байранд нийт 12 удаа дэмжих бүлэг  
хичээллүүлжээ.

Дархан-Уул аймаг, Хүчирхийллийн  
Эсрэг Үндэсний Төвийн салбар  
зөвлөл, "Чадавхи бэхжүүлэх" төсөл  
934.000 ₮

Түрээсийн ажлын байртай болсноор  
"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх  
тухай хууль"-ийг хэрэгжүүлэхэд  
нөлөөлөх, хүчирхийлэлд өртсөн  
эмэгтэйчүүд, хүүхэд, иргэдэд  
үзүүлэх үйлчилгээ, мөн хүчирхийлэл  
үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх  
үйлчилгээг тогтмолжуулна.

/тэтгэлэгийн хугацаа дуусаагүй/

Сайн Дурын Байгууллагуудын  
Үндэсний Сүлжээ, "Байгууллага  
чадавхижуулах" төсөл  
500.000 ₮

Утас, холбоо, түрээсийн ажлын  
байраар хангагдсанаар сайн дурын  
үүсгэл санаачлагын байгууллагуудыг

чадавхижуулах төрөл бүрийн сургалт  
зохион байгуулах, сайн дурын үйл  
ажиллагааг түгээн дэлгэрүүлэх олон  
талт ажлуудыг зохион байгуулна.

/тэтгэлэгийн хугацаа дуусаагүй/

Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг  
хамгаалах "ГҮНЖ" төв, "Чадавхи  
бэхжүүлэх" төсөл 1.000.000 ₮

Ажлын байр, байнгын ажиллагаатай  
гүйцэтгэх албатай болсноор  
бэрхшээлтэй асуудалтай олон охид  
тэр дундаа насанд хүрээгүй байхдаа  
хүүхэд төрүүлсэн охидод хүрч ажил-  
лах, ингэснээр тэднийг нийгмийн  
хөгжилд идэвхи санаачлагатай  
оролцоход нь нөлөөлнө.

/тэтгэлэгийн хугацаа дуусаагүй/

Монголын Фермер Эмэг-  
тэйчүүдийн Холбоо, "Байгууллага  
чадваржуулах" төсөл  
1.000.000 ₮

Интернэт тогтмол ашиглаж,  
байгууллагын дотоод гадаад харилцаа  
өргөжсөнөөр үйл ажиллагаа  
тогтворжино. Амьжиргааны баталгаат  
түвшингээс доогуур амьдралтай өрх,  
болгонд эмэгтэйчүүдийн орлогыг  
нэмэгдүүлэх, фермэрийн аж ахуй  
эрхлэхэд нь тусалж, амьдрах ухааны  
төрөл бүрийн сургалт зохион  
байгуулна.

/тэтгэлэгийн хугацаа дуусаагүй/

Хөвсгөл аймаг, Мөрөн хот,  
Эмэгтэйчүүдийн бүлэг,  
"Эмэгтэйчүүд ТББ" төсөл  
500.000 ₮

Орон нутгийн эмэгтэйчүүдийн  
хэрэгцээг нарийвчлан судлах,  
эмэгтэйчүүдийн байгууллагын  
чадавхийг бэхжүүлэх чиглэлд онцлон

анхаарч ажиллахаар бэлтгэж байна.  
Тухайлбал, эмэгтэйчүүдийн эрх,  
жөндөрийн тэгш байдлаар сургалт  
явуулах, ТББ-ын бүтэц зохион  
байгуулалт, төлөвлөлт зэрэг асуудлаар  
сургалт явуулж эхлээд байна.

/тэтгэлэгийн хугацаа дуусаагүй/

Ардчиллын Боловсролын Төв,  
"1%-ийн татварын санаачлага"  
төсөл 665.000 ₮

Иргэд өөрсдийн төлж буй хүн амын  
орлогын албан татвараас 1%-  
ийг нь дэмжиж байгаа төрийн бус  
байгууллагадаа хандивлаж байх  
хөдөлгөөнийг өрнүүлж байгаа бөгөөд  
1%-ийн татварын хуулийн талаар  
Европын орнуудын тэргүүн туршлагыг  
УИХ, Засгийн газар, ТББ-ын  
төлөөлөгчдөд мэдээлэх, танилцуулах  
уулзалтуудыг зохион байгуулж, энэ  
талаар нөлөөллийн үйл ажиллагаа  
явуулна.



## ГЭНЭТИЙН ТУСЛАМЖИЙН САНГААС ТЭТГЭЛЭГ ОЛГОЛОО

Гэнэтийн Тусламжийн Сангаас эмзэг бүлгийн, өрх толгойлсон, олон хүүхэдтэй, орлогогүй 12 эмэгтэйд 576 510 төгрөгийн нэг удаагийн мөнгөн тусламж үзүүлэв. Мөн сайн санаат иргэд, буяны байгууллагаас МОНЭС-д хандивласан хуучин, шинэ хувцас, хичээлийн хэрэгсэл, үзвэрийн тасалбар, ногооны үр зэрэг 1 251 000 төгрөгийн үнэ бүхий эд зүйлсийг эмэгтэйчүүдэд тараалаа.



# ТЭТГЭЛЭГИЙН ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС...



## ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР

Монголын Эмэгтэйчүүдийн Сан, Эмэгтэй Удирдагч Сан хамтран 2005 оны 3 дугаар сарын 8-ны өдөр буюу Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Чингис" цогцолборт "ЭМЭГТЭЙЧҮҮД БА НИЙГМИЙН ӨӨРЧЛӨЛТ" сэдэвт бага хурлыг зохион байгууллаа. Тус бага хуралд МУ-ын Засгийн Газрын Тэргүүн, Ерөнхий сайд Ц. Элбэгдорж, УИХ-ын эмэгтэй гишүүд, төрийн болон иргэний нийгмийн зүтгэлтэн эмэгтэйчүүд оролцлоо.

### Хурлын үеэр:

1. МОНЭС-аас тэтгэлэг авсан бүлгүүд өөрсдийн үйл ажиллагаа болон нийгмийн тулгамдсан асуудлуудын талаар дараах сонирхолтой илтгэлүүдийг тавилаа.

"Нарантуул ОУХТ-д худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн нөхцөл байдал"

Залуу Лидер Эмэгтэйчүүд Клубын Тэргүүн О.Баяртуяа

"Ажлын байран дахь бэлгийн дарамтлалын эсрэг ажиллагаа-Монголд"

Монголын ЭТББ-ын Эвслийн Гүйцэтгэх захирал М. Амарая

"Өсвөр насандаа хүүхэд төрүүлсэн охидын эрхийн асуудал"

Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах "ГҮНЖ" төвийн Тэргүүн Ч.Ундрах

"Гар урлал ба эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдал"

Эмэгтэйчүүд, Хүүхэд Хөгжлийн "ЭХ САН" төвийн Гүйцэтгэх захирал Х.Доржханд

"Хөдөөгийн эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхи"

Хөдөөгийн Эмэгтэйчүүдийн Хөгжлийг Дэмжих Сангийн Гүйцэтгэх захирал М.Мэндбаяр

"Бусдыг хайрлах, тэтгэн туслах филантропи үзэл хандлага ба нийгмийн өөрчлөлт"

МОНЭС-ийн Захирал Н. Чинчулуун

"Хохирогч хохирогчоороо үлдэх үү?" Хүйсийн Тэгш Эрхийн Төвийн тэргүүн Г.Ганбаясгах

2. МОНЭС-аас тэтгэлэг авахаар шалгарсан 12 эмэгтэйчүүдийн бүлгүүдэд батламж бичгийг гардуулах ёслолын ажиллагаа болсон бөгөөд батламжийг МУ-ын Ерөнхий сайд Ц. Элбэгдорж гардууллаа.

3. "2005 оны Нийгмийн зүтгэлтэн эмэгтэй"-г шалгаруулж 1 сая төгрөгийн мөнгөн шагнал гардуулав.

МОНЭС ОУ-ын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр буюу 3-р сарын 8-ныг тохиолдуулан эмэгтэйчүүдийн хүний эрх, эмэгтэйчүүдийн хөгжил, иргэний нийгмийн төлөө үнэлэхүйц хувь нэмэр оруулсан ЭТББ-ын ажилтан нэг эмэгтэйг шалгаруулах болзолт уралдааныг зарласан.

Уралдаанд ХЭҮТ-ийн Гүйцэтгэх захирал Д. Энхжаргал шалгарсан юм. Тэрээр нийгмийн хамгийн бэрхшээлтэй асуудлын нэг гэр бүл дэх болон эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх тогтолцоог боловсронгуй болгоход байгууллагаа амжилттай удирдан хүний эрх, эмэгтэйчүүдийн эрх, эмэгтэйчүүдийн аж байдлыг дээшлүүлэхэд эргэлт гаргаж, нийгмийн сэтгэл зүйд өөрчлөлт хийсэн ба улмаар төрийн гүйцэтгээгүй үүргийг гүйцэтгэсэн бөгөөд түүний ажлын арга барил, зарчим, асуудлыг шийдвэрлэх хандлага, тууштай хичээнгүй зүтгэл нь энэхүү шагналыг авахад зүй ёсоор хүргэсэн юм.





**"2005 ОНЫ НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН ЭМЭГТЭЙ"-гээр Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн Гүйцэтгэх Захирал ДАВААСҮРЭНГИЙН ЭНХЖАРГАЛ шалгарч "Өргөмжлөл", 1 000 000 төгрөгийн эзэн боллоо.**

## **MAKING THE CASE БҮЮУ «ТОХИОЛДЛЫГ БИЙ БОЛГОХ НЬ» ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ ЯВАГДЛАА**

Making The Case /MTC/ буюу "Тохиолдлыг бий болгох нь" үнэлгээний аргачлал нь АНУ-ын Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээний нэлээд хэдэн жилийн үйл ажиллагааны үр дүн бөгөөд байгууллагуудын төсөл, хөтөлбөрийг дүгнэхэд зориулагдсан юм. Өөрөөр хэлбэл онлайн-аар төсөл хэрэгжүүлэгч нь өөрийнхөө хэрэгжүүлж буй төслийн үр дүнг үнэлэхээр хийгдсэн хэрэгсэл юм. Энэхүү хэрэгсэлийг дэлхийн хэмжээнд хэрэглэхэд ойлгомжтой, үр ашигтай байлгахын тулд ЭСС нь түүнийг ашиглаж эхлэхээс өмнө 5 тивийн байгууллагуудаас санал авч, уулзалт, сургалтуудыг зохион байгуулсан юм. МОНЭС-ийн баг 3 үе шатны сургалтанд хамрагдсан.

### **НЭГ. Европын Эмэгтэйчүүдийн Сангуудын уулзалт /Прага хот/**

2005 оны 3 сарын 18-19-нд Бүгд Найрамдах Чех улсын нийслэл Прага хотноо Европын Эмэгтэйчүүдийн сангуудын

уулзалтанд МОНЭС-ийн Удирдах Зөвлөлийн Гишүүн Б. Нандинчимэг, Тэтгэлэг олгох хөтөлбөрийн захирал Д. Пүрэвсүрэн, Мэдээллийн ажилтан Ч. Ундрах, тэтгэлэг авагч байгууллагуудын төлөөлөгчид болох ХЭХДС-ийн Ерөнхийлөгч Ч.Отгонбаяр, ХЭҮТ-ийн Гүйцэтгэх захирал Д. Энхжаргал нар оролцлоо.

Уулзалтын үеэр "Making The Case" үнэлгээний хэрэгсэл дээр ажиллаж санал бодлоо солилцлоо. Оролцогчид энэхүү хэрэгсэлийг ач холбогдолтой, ялангуяа жижиг төсөл, хөтөлбөр, мөн бүхэл байгууллагын нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг үнэлэх боломжтой хэрэгсэл гэж үзсэн ба оролцогчид өөр өөр түвшний соёл, хэлтэй хүмүүст ашиглахад дөхөмтэй, хялбар байх талыг анхаарахыг зөвлөлөө.

### **ХОЁР. МОНЭС-ийн хамт олонд зориулсан сургалт Улаанбаатар хотод болов.**

2005 оны 9 сард Нидерландын Мама Каш сангийн зөвлөх Gisela Dutting Улаанбаатар хотод хүрэлцэн ирж, МОНЭС-ийн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх алба, сайн

дурынханд "нийгмийн өөрчлөлтийн онол, МТС үнэлгээ хийх, Монголд МТС-г хэрхэн ашиглах" талаар 2 өдрийн сургалт явууллаа. МТС хэрэгсэл дээр сургагч багшийн хамт ажиллаж, нийгмийн өөрчлөлтийг макро болон микро түвшинд хийж болдог ба жижиг төсөл ч нийгмийн өөрчлөлтийг авчирдаг талаар, МОНЭС-аас олгож байгаа тэтгэлэгүүд нийгэмд ямар өөрчлөлт хийж байгаа талаар маш тодорхой дүр зураглалтай болцгоосон.

### **ГУРАВ. МОНЭС-ийн тэтгэлэг авагч бүлгүүдэд зориулж сургалт явуулав.**

2005 оны 11 сарын 18-нд МОНЭС-аас тэтгэлэг авсан ХЭХДС, ХЭҮТ, Багануур дүүргийн ЭТББ-ын Сүлжээ, ЛЭОС, Налайх дүүргийн МЭБАХЭХ-ны салбарыг хамруулж МТС хэрэгсэлийг ашиглан хэрэгжүүлсэн төслүүдийг үнэлсэн юм. Мөн үүний дараа 11 сарын 28-30-нд Нидерландын Мама Каш сангийн зөвлөх Gisela Dutting Улаанбаатар хотод хүрэлцэн ирж дээрх байгууллагуудтай ажиллав.



МОНЭС-ийн төлөөлөгчид уулзалтын үеэр /Прага хот/



МТС сургалтын үеэр Улаанбаатар хот



## ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БҮЛГҮҮДИЙГ СУРГАЛТАНД ХАМРУУЛЛАА



"Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл"  
сургалтын үеэр

Эмэгтэйчүүдийн бүлгүүдийн чадавхийг сайжруулах, хэрэгжсэн төслийн чанар, түүнээс гарах үр өгөөжийг дээшлүүлэх үүднээс тэтгэлэг олгохдоо бүлгүүдийг тухайн чиглэлээр нь сургалтанд хамруулахыг зорьж ажиллалаа. Амьдрах ухааны чиглэлээр олгосон 12 төслийг хэрэгжүүлэгч байгууллагуудын төлөөлөгчдийг жижиг дунд бизнесийн 2 өдрийн сургалтанд хамруулсан нь үр дүнгээ өгч анхан шатны санхүүгийн тооцоо, бизнес төлөвлөгөөг зохих журмын дагуу гаргаж сурсан.

## ХӨДӨӨ ОРОН НУТАГТ АЖИЛЛАЛАА



Хөвсгөл аймаг, Хатгал тосгоны гар урлал хийж буй эмэгтэйчүүдтэй уулзаж байгаа нь

МОНЭС-ийн баг Төв, Ховд, Хөвсгөл аймгийн Мөрөн сум, Хатгал тосгон, Дархан-Уул аймгийн Дархан хот, Орхон сум, Сэлэнгэ аймгийн Ерөө, Дулаанхаан сум, Багануур дүүргийн эмэгтэйчүүдийн бүлгүүдийн үйл ажиллагаатай танилцаж, санал бодлоо солилцлоо.

## ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭМЭГТЭЙ- ЧҮҮДИЙН БҮЛГҮҮДИЙГ ЧАД- ВАРЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЛАА

### 1. МОНЭС-ийн баг Хөвсгөл аймагт ажиллалаа



Хөвсгөл аймгийн эмэгтэйчүүдийн  
бүлгүүдтэй уулзалт хийх үеэр

2005 оны 7 сарын 16-аас 22-ны өдрүүдэд МОНЭС-ийн Зөвлөх Б.Оюунбилэг, Захирал Н. Чинчулуун, тэтгэлэг олгох хөтөлбөрийн захирал Д. Пүрэвсүрэн болон ОУЭСС-ний зөвлөх Мариа Елена Мартинез нар Хөвсгөл аймгийн Мөрөн, Хатгал тосгонд ажиллалаа.

Мөрөн хотод эмэгтэйчүүдийн байгууллага, бүлгүүдийн төлөөлөгчид болох 25 хүнд "Эмэгтэйчүүдийн хүний эрх" сэдвээр 1 өдрийн сургалт явууллаа. Сургалтын үеэр Хөвсгөл аймгийн эмэгтэйчүүдэд тулгарч буй бэрхшээлүүд, түүнийг хэрхэн шийдвэрлэх арга замын талаар ярилцлаа.

Хатгал тосгоны тосгонд 2004 онд МОНЭС-ийн санхүүжилтээр хэрэгжсэн "Сүү шим" төслийн сургалтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн төлөөлөгчидтэй уулзалт хийж, өмнө хэрэгжсэн төслийн хэрэгжилт, гарсан үр дүн, мөн Хатгал сумын эмэгтэйчүүдийн асуудлаар чөлөөт ярилцлага хийж санал бодлоо солилцлоо.

Эмэгтэйчүүдийн санал бодлыг харгалзан, тэднийг хөгжүүлэхийн тулд Хөвсгөл аймгийн эмэгтэйчүүдийн бүлгийнхний төлөөлөл оролцсон сургалтын аянг Улаанбаатар хотод зохион явуулахаар шийдвэрлэсэн юм.

*Хүн сайн үйлс бүтээх  
газвартай байхад, агийг үн  
санах явдалтай тулгарах  
аюул нүүрлэхгүй*

*Нарошфучо*

*Сайхан сэтгэл бол хэний  
хүмүүс ярьж гаддаг дүний  
хүмүүс сонсож гаддаг хэл юм.*

*Кристиан Бочви*

*Өгөөмөр байна гэдэг ихийг  
өгөхдөө г бус цагийг нь олж  
өгөхдөө бас байдаг юм.*

*Жан Де Лабрюйер*



*Сайн юм хийх тухай хэтэрхий удаан бодож байгаа хүнд сайн хүн байх цаг олдоггүй.*

*Рабиндраканит Шаагур*

*Хүнийг байх эсэх нь зөвхөн биднээс өөрсдөөс маань хамаарна. Жинхэнэ хүнийг хүн бүсдэг хайрлах г, шударга бус зүйлийг үзэн ядах г гадвартай байдаг.*

*Күнз*

## 2. Сургалтын аян зохион байгууллаа



Хөвсгөл аймгийн эмэгтэйчүүд "Дүүрэн санаа" ТББ-ын үйл ажиллагаатай танилцах үеэр

Хөвсгөл аймгийн Мөрөн, Хатгал сумын эмэгтэйчүүдийн бүлгүүдийн 9 төлөөлөгчийг Улаанбаатар хотын ЭТББ-уудын үйл ажиллагаатай танилцуулж туршлага судлуулах 7 хоногийн сургалтын аян зохион байгууллаа.


Хөвсгөл аймгийн эмэгтэйчүүд эмэгтэйчүүдийн хүний эрх, монголын эмэгтэйчүүдийн хөдөлгөөний бодит дүр төрхтэй танилцаж, эмэгтэйчүүд

хэрхэн зорилгоо тодорхойлж, түүнд хүрэх арга замуудыг сонгож байгаа, хэрхэн хамтарч ажиллаж амжилтанд хүрч болдогийг бодитоор олж харсан юм. Төлөөлөгчид эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар CEDAW watch, ЛЭОС, ХЭХДС, "ГҮНЖ" төв, ХЭҮТ зэрэг байгууллагууд мөн эдийн засгийн чиглэлээр "Бат байгаль" талх нарийн боовны тэргүүлэх компани дээр 3 өдрийн дадлага хийсэн.

Мөн орон нутагт ЭТББ-ын хамтын ажиллагааны шилдэг жишээ болсон Багануур дүүргийн ЭТББ-ын Сүлжээтэй танилцсанаар тухайн түвшинд хязгаарлагдмал бололцоотой нөхцөлд хэрхэн бие биеэ дэмжиж ажиллахыг тодоор харуулж өгсөн нь Хөвсгөлийн эмэгтэйчүүдийн байгууллагууд цаашдаа амжилттай ажиллах зураглалыг бий болгосон юм.

## МАЛЖУУЛАХ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА


Германы Эмэгтэйчүүдийн Сангийн санхүүжилтээр МОНЭС анх удаа малжуулах төсөл хэрэгжүүлэх эхлэлийг тавьж, Улаанбаатар хотын ойролцоох Төв аймгийн Угтаал суманд Төв аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран 50 төлөг, 50 борлонг худалдан авч малчин айлд өсгөн үржүүлэхээр өглөө. Эдгээр малын дийлэнх нь төллөх эм мал бөгөөд ирэх 2006-2007 онд малын өсөлтөөс хамаарч үр төлийг нь шилжүүлэх замаар Хөвсгөл болон Төв аймгийн эмэгтэйчүүдийг малжуулах зорилготой юм.





# САН БҮРДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Та бидэнд хандив өргөнө үү,  
Бид нийгмийг хөгжүүлэхэд хувь  
нэмэр оруулья!





## ТАНИЛЦУУЛГА

МОНЭС тэтгэлэг авагч бүлгүүдээр дамжуулан эмэгтэйчүүдэд хүрч нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтийг авчрахын төлөө хөрөнгө босгох олон талт ажлуудыг хийж байна.

Эмэгтэйчүүдэд тулгардаг бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхийн төлөө нинжин сэтгэлийг гараа сунгаж хандив өргөдөг гадаад, дотоодын хувь хүмүүс, байгууллагуудын туслалцаа дэмжлэгээр төсөлд хамрагдсан охид, эмэгтэйчүүдийн амьдралд бодит өөрчлөлтүүд гарч байна.

### МОНЭС:

- Өнгөрсөн хугацаанд 2430 хандивлагчтай болоод байна.
- Хандивлагч байгууллагын тоо урьд онуудтай харьцуулбал 3 дахин өслөө.

Цаашдаа байнгын хандивлагчдын тоог нэмэгдүүлэх, "Хандивлагч" гишүүнчлэлийг бий болгон ажиллах зорилго тавиад байна.

## ХАНДИВЛАГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ



МОНЭС-ийн байнгын хандивлагч М.Болор-Уянга:


Завхан аймгийн Улиастай сумын "Тэгш хэм" дунд сургуулийн 4а ангийн сурагч

"Хүнд дандаа тусалж бай, тэгвэл хүн чамд дараа нь тусална." гэж ээж маань дандаа хэлдэг юм. Тийм учраас "эмээг бүлгийн охидуудад туслаарай" гэж өөрийн хандиваа МОНЭС-т өргөсөн юм.

Мөн Монголын Эмэгтэйчүүдийн Сангийн эгч нартаа зориулж өөрийн зохиосон шүлгээрээ бэлэг барьж байна.

### БОРОО

Бороо чи тэнгэрээс буусан ус юм уу?  
 Бороо чи тэнгэрийг эзэгнэгч хаан юм уу?  
 Хэрвээ би бороосон бол  
 Өндөр тэнгэрээс бууж ирээд  
 Хүүхэд болгоныг баярлуулж  
 Хөвчийн ойг шүүдрээрээ мялаах даа  
 Хүн бүрийн тус бороо шиг байгаасай ...гэж хэлнэ.



МОНЭС-ийн байнгын хандивлагч байгууллага "Ar Mongol Travel" ХХК-ийн захирал Т.Батжаргал:

Монгол Улсад ядуурлыг бууруулах, ажлын байр шинээр бий болгох үйлсэд тус сангаас явуулж буй үйл ажиллагаагаар дамжуулан "Ar Mongol Travel" ХХК-аас өргөсөн хандив өчүүхэн боловч хувь нэмэр болох болтугай.



## САН БҮРДҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

**ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙ-  
ЧҮҮДИЙН ЭРХИЙН ӨДӨР**  
/2005.03.08/



“Harley face” клубт хөрөнгө босгох үдшийн цэнгүүнийг зохион байгууллаа. Үдшийн цэнгүүнд СУИС багш Б. Даваа, УБДҮЧ-ын дуучин Г. Ганбат, ДБЭТ-ын дуучин С.Оюунчулуун, дуучин Ц.Баттөр, “Энхлүүн” эмнэлгийн эрхлэгч Д. Алтанцэцэг нар өөрсдийн ая дуугаа өргөсөн ба нийтдээ 47 хүн оролцож хандив өргөсөн.



**ХҮҮХДИЙН ЭРХИЙН ӨДӨР**  
/2005.05.31 - 2005.06.01/



Эх үрсийн баярын өдрөөр “Сарны Титэм” ХХК буюу үзэсгэлэн чимэглэлийн өмнөх талбайд ЭТББ-ын гар урлалын үзэсгэлэн худалдаа болон сан бүрдүүлэх өдөрлөгийг зохион явууллаа. Үзэсгэлэн худалдаанд ХЭҮТ, Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах “ГҮНЖ” төв, Төв аймгийн Эмэгтэйчүүдийн Зөвлөл, Налайх дүүргийн Эмэгтэйчүүдийн Зөвлөл, “ЭХ САН” төв, “Өөдрөг эхлэл хоршоо” зэрэг ЭТББ-ууд өөрсдийн үйл ажиллагааныхаа сурталчилгааг явуулсан бөгөөд урласан гар урлалын бүтээгдэхүүнээ худалдаж борлуулсан.



**КОФЕ УУЛЗАЛТ**  
/2005.06.24/

“Нийгэм дэх эмэгтэйчүүдийн байдал” сэдэвт чөлөөт ярилцлагыг “Nayra Cafe”-д зохион явууллаа. Уулзалтанд амжилттай ажиллаж байгаа 5 компанийн захирал эмэгтэй хүрэлцэн ирсэн бөгөөд өнөөгийн монголын эмэгтэйчүүдийн нөхцөл байдал ямар байна, бэрхшээлтэй байгаа асуудалд цаашдаа хэрхэн хамтарч ажиллах талаар ярилцаж санал солилцсон. Тэдгээр эмэгтэйчүүд МОНЭС-т мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр хандив өргөсөн.



## САН БҮРДҮҮЛЭХ КАМПАНИТ АЖЛУУД

**Хөгжлийн Бэрхшээлтэй  
Охидод Туслах Аян**  
/2005.08.20-2006.02.20/



2005 оны 8 сарын 20-оос эхлэн “Хөгжлийн Бэрхшээлтэй Охидод Туслах” 6 сарын сан бүрдүүлэх аянг зохион явууллаа.

### АЯНЫ ХҮРЭЭНД:

- 3 өдрийн гудамжны жижиг худалдаа зохион байгуулсан.
- Охидын цаашдын амьдралд хувь нэмэр оруулах, туслах боломж бүхий байгууллага, компани, хувь хүмүүсийг урьж оролцуулсан “Пицца” чөлөөт уулзалт зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд охидыг даатгалд хамруулах, тэдэнд хадгаламжийн дэвтэр нээлгэх, шинээр ажлын байр бий болгох зэрэгт туслалцаа, дэмжлэг үзүүлэх боломжтой болсон.
- Батбайгаль ХХК, Науга кафе, Хаан банкны 8-н салбарт хандивын хайрцаг байрлуулж, байгууллага, хувь хүмүүсээс хандив цуглууллаа.
- Хаан банкны захирал Петер Морроу хөгжлийн бэрхшээлтэй охидын зургийн авьяасыг хөгжүүлэхэд нь зориулж 500000 төгрөгийн хандив өргөлөө.
- “Lady” төвтэй хамтран ажилласан бөгөөд тус төв нь байнгын хандивлагч болохоор ажиллаж байна.

**Олон Улсын Филантропи  
Өдөр /2005.11.15-2005.11.17/**



“Тэнгэрийн цаг” цогцолборт “Бусдыг хайрлах, тэтгэн туслах-Филантропи үзэл” сэдвээр лекц зохион байгуулсан. Лектор Шири Шири Амьдрах Ухаан Төвийн захирал Ц. Саранцэцэг, Монголын Фенг Шүйгийн Холбооны ерөнхийлөгч С. Ганбаатар нар өөрсдийн чадварлаг авьяас, оюун ухаан, үнэт мэдлэгээ хандивласан юм. Лекцэнд оролцсон 66 хүн МОНЭС-т хандив өргөсөн.



**88 ӨДРИЙН АЯН**  
/2005.12.10-2006.03.08/



Олон Улсын Хүний эрхийн өдөр 2005 оны 12-р сарын 10-наас Олон улсын Эмэгтэйчүүдийн Эрхийн өдөр 2006 оны 3-р сарын 8 хүртэл 88 өдрийн сан бүрдүүлэх аянг Ази дахь эмэгтэйчүүдийн сангууд хамтран зохион байгуулж байна.




Монгол



Heran



Nirvana



HER Fund

МОНЭС энэхүү аяны хүрээнд нийт 1000 хүнээс хандив цуглуулахаар зорилт тавьсан бөгөөд оролцогч нь 88 хоногийн турш өдөрт 100 төгрөгийг хандивийн гэрт цуглуулах юм. Ингэснээр нэг гэрээс 8800 төгрөг нийт 8 800 000 төгрөг цуглуулна. Цугларсан мөнгийг нийгэмд далд хэлбэрээр үйлдэгддэг, хор хөнөөл учруулж байдаг “Ажлын байран дахь бэлгийн дарамтлал”-ыг /АББД/ бууруулах үйл ажиллагаанд зориулж хандив болгон өгнө.



88 өдрийн аяны бэлэг тэмдэг  
“Монгол гэр” хандивын хайрцаг



# ГЭГЭЭРЛИЙН ХӨТӨЛБӨР

Нэг хүний тус нөгөө хүний  
амьдралыг өөрчлөх  
аугаа их шидтэй ажгуу.

